ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**Үенч сумын Сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

**Аудитын код: ХОА-2022/91/НА/-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn
Ховд хот
2022 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар
Утас: 70433061
Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн
Утас:70432545
Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn
Хо Өрлөгийн Үрс Аудит ХХЗ-ны
Аудитор: А.Оюундэлгэр
Утас: 99306289
цахим хаяг: a_oyund@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга


2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ....3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ....6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....8
3. Аудитын тайлан ....10
**3.1 Ерөнхий зүйл** ....10
**3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт** ....10
**3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал** ....11
**3.4 Материаллаг байдал** ....11
**3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга** ....12
**3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв** ....12
**3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг** ....13
**3.8 Аудитын гол асуудал** ....13
**3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** ....13
**3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** ....14
**3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт** ....14
**3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал** ....14
**4. Аудитын илрүүлэлт** ....14
**4.1 Залруулсан алдаа** ....14
**4.3 Албан шаардлага** ....14
**4.4 Зөвлөмж** ....14
**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл** ....15


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ЕБС | Ерөнхий боловсролын сургууль |
| НА | Нотлох ажил |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2022.02.24 № 02/22

танай ____________ -ны № ____________ -т

ҮЕНЧ СУМЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Л.НЯМЖАРГАЛ ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Үенч сумын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ховд аймгийн Үенч сумын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй , төсөв хооронд гүйлгэн зарцуулсан нь төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах зарчмыг баримтлан ажиллаагүй, төсвийн зардлыг хэмнэх тогтоолтыг хэрэгжүүлээгүй нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.БОЛДБААТАР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **47,748,109** | **53,110,952** |
| **33** | **АВЛАГА** | 3,345,241 | 13,518,204 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 1,000,000 | 518,204 |
| **335** | **Бусад авлага** | 9,941 | 13,000,000 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 9,941 | 13,000,000 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 44,402,868 | 39,592,748 |
| **351** | **Түүхий эд материал** | 4,019,500 | 4,019,500 |
| 35130 | Эм боох материал | 4,019,500 | 4,019,500 |
| **354** | **Хангамжийн материал** | 40,383,368 | 35,573,248 |
| 35420 | Аж ахуйн материал | 00 | 3,500 |
| 35460 | Хүнсний материал | 7,849,825 | 6,434,000 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 29,135,748 | 29,135,748 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **3,294,345,172** | **3,198,746,826** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 3,294,345,172 | 3,198,746,826 |
| **392** | **Биет хөрөнгө** | 3,174,345,172 | 3,078,746,826 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 3,357,258,589 | 3,357,258,589 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -306,003,949 | -420,080,855 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 33,300,000 | 33,300,000 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -33,300,000 | -33,300,000 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 222,075,227 | 239,466,227 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -201,365,824 | -207,217,613 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 175,092,806 | 192,896,858 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -84,646,117 | -95,836,820 |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 8,000,000 | 8,000,000 |
| 39217 | Ном | 3,934,440 | 4,260,440 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 120,000,000 | 120,000,000 |
| 39301 | Програм хангамж | 1,130,000 | 1,130,000 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,130,000 | -1,130,000 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 120,000,000 | 120,000,000 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **3,342,093,281** | **3,251,857,777** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **3,341,887,240** | **3,251,857,777** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 3,341,887,240 | 3,251,857,777 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 541,754,600 | 541,754,600 |
| 51101 | Өмч: - төрийн | 541,754,600 | 541,754,600 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 1,762,981,163 | 1,672,951,700 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,762,981,163 | 1,762,981,163 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00 | -90,029,462 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,037,151,477 | 1,037,151,477 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **3,342,093,281** | **3,251,857,777** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,517,182,801** | **1,281,880,837** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **267,071,501** | **31,543,352** |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | 267,071,501 | 31,543,352 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 267,071,501 | 31,543,352 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00 | 1,818,300 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 600,000 | 600,000 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 266,471,501 | 29,125,052 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **51,974,000** | **90,064,679** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,198,137,300 | 1,160,272,806 |
| 1311 | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 626,000 | 32,759,943 |
| 131102 | Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл | 00 | 8,000,000 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 500,000 | 24,759,943 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 126,000 | |
| 1320 | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 51,348,000 | 52,160,400 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 51,348,000 | 52,160,400 |
| 1340 | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 00 | 5,144,336 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 00 | 5,144,336 |
| 2 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,347,906,882** | **1,371,910,299** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,347,906,882** | **1,371,910,299** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,292,910,474 | 1,306,404,234 |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 951,146,295 | 924,929,781 |
| 210101 | Үндсэн цалин | 946,678,869 | 924,775,001 |
| 210102 | Нэмэгдэл | 3,630,879 | 154,780 |
| 210104 | Урамшуулал | 836,547 | |

| | | | |
|---|---|---|---|
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 120,405,038 | 119,916,352 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 120,405,038 | 119,916,352 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 51,618,905 | 49,785,650 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,633,500 | 5,478,955 |
| 210302 | Түлш, халаалт | 43,832,405 | 44,306,695 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 153,000 | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 6,637,800 | 7,724,937 |
| 210401 | Бичиг хэрэг | 562,200 | 1,109,900 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,416,000 | 2,946,540 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 726,100 | 363,600 |
| 210404 | Ном, хэвлэл | 12,000 | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 271,600 | 1,404,897 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,623,900 | 1,900,000 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 26,000 | |
| **2105** | **Нормативт зардал** | 37,162,050 | 47,275,675 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,927,400 | 648,600 |
| 210502 | Хоол, хүнс | 32,625,115 | 44,165,575 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,609,535 | 2,461,500 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 648,000 | |
| 210604 | Урсгал засвар | 648,000 | |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 109,500 | 354,000 |
| 210702 | Дотоод албан томилолт | 109,500 | 354,000 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 392,000 | 6,960,000 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 00 | 6,240,000 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 392,000 | 720,000 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 124,790,887 | 149,457,839 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 545,000 | 13,985,241 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,327,600 | 4,353,200 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 118,918,287 | 131,119,399 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 54,996,408 | 65,506,065 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 18,779,400 | 55,401,610 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 00 | 5,144,336 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 18,779,400 | 32,033,150 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад | 00 | 18,224,124 |

| | | | |
|---|---|---|---|
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 36,217,008 | 6,198,561 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 36,217,008 | 6,198,561 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 00 | 3,905,894 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00 | 3,905,894 |
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **169,275,919** | **-90,029,462** |
| 5 | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **169,275,919** | **-90,029,462** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

төгрөгөөр

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C08 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **541,754,600** | **1,037,151,477** | **1,762,981,163** | 3,341,887,240 |
| D01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **541,754,600** | **1,037,151,477** | **1,762,981,163** | 3,341,887,240 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00 | 00 | 00 | 00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 541,754,600 | 1,037,151,477 | 1,762,981,163 | 3,341,887,240 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00 | 00 | 00 | 00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00 | 00 | 00 | 00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз | 00 | 00 | 00 | 00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00 | 00 | 00 | 00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00 | 00 | -90,029,462 | -90,029,462 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 541,754,600 | 1,037,151,477 | 1,672,951,700 | 3,251,857,777 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 1252420600 | 1252755785 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | **2309300** | **2418300** |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | 2309300 | 2418300 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 2309300 | 2418300 |

| | | | |
|---|---|---|---|
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 0 | 1818300 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 600000 | 600000 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 1709300 | |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1250111300** | **1250337485** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1198137300 | 1160272806 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 626000 | 32759943 |
| 131102 | Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан. ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл | 0 | 8000000 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 500000 | 24759943 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 126000 | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 51348000 | 52160400 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 51348000 | 52160400 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 0 | 5144336 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 0 | 5144336 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1252420600** | **1252755785** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1252420600** | **1252755785** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1195088892** | **1187249720** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 954529252 | 920753278 |
| 210101 | Үндсэн цалин | 705123778 | 727480958 |
| 210102 | Нэмэгдэл | 194146989 | 167512716 |
| 210104 | Урамшуулал | 55258485 | 25759604 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 128913700 | 124317100 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 90631200 | 87482500 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9570500 | 9208500 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8128800 | 6986600 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1441900 | 2222100 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 19141300 | 18417400 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 48463100 | 47442106 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7633500 | 5963206 |
| 210302 | Түлш, халаалт | 40259600 | 40908900 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 570000 | 570000 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 6842100 | 8259637 |
| 210401 | Бичиг хэрэг | 562900 | 1053022 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3416000 | 2946540 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 726100 | 726100 |
| 210404 | Ном, хэвлэл | 392000 | 400400 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 271100 | 1539975 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1474000 | 1593600 |
| **2105** | **Нормативт зардал** | 49464440 | 45513250 |

| | | | |
|---|---|---|---|
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 7063400 | 746400 |
| 210502 | Хоол, хүнс | 32699240 | 42431650 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 9701800 | 2335200 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 650000 | 1412400 |
| 210604 | Урсгал засвар | 650000 | 1412400 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 109500 | 354000 |
| 210702 | Дотоод албан томилолт | 109500 | 354000 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 392000 | 8720000 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 0 | 8000000 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 392000 | 720000 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 5724800 | 30477949 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 545100 | 26189049 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5179700 | 4288900 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **57331708** | **65506065** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 18779400 | 55401610 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 0 | 5144336 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 18779400 | 32033150 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 0 | 18224124 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 38552308 | 6198561 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 38552308 | 6198561 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 0 | 3905894 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 0 | 3905894 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 0 | - |
| | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 0 | - |
| 4 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4) | 0 | |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 0 | |
| 9 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 0 | |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 0 | |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| 1 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,213,033,200.00 | 1,202,928,744.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,213,033,200.00 | 1,170,895,594.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,178,660,700.00 | 1,170,895,594.0 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 903,267,100.00 | 920,753,271.00 |
| 210101 | Үндсэн цалин | 625,276,300.00 | 727,480,951.00 |
| 210102 | Нэмэгдэл | 224,145,400.00 | 167,512,716.00 |
| 210104 | Урамшуулал | 53,845,400.00 | 25,759,604.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 121,941,100.00 | 124,317,100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 85,810,500.00 | 87,482,500.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,032,500.00 | 9,208,500.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,226,200.00 | 7,367,000.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,806,500.00 | 1,841,700.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 18,065,400.00 | 18,417,400.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 51,348,000.00 | 47,442,106.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,869,100.00 | 5,963,206.00 |
| 210302 | Түлш, халаалт | 40,908,900.00 | 40,908,900.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 570,000.00 | 570,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 6,588,300.00 | 6,583,818.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 619,200.00 | 619,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,950,900.00 | 2,946,540.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 726,100.00 | 726,100.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 400,400.00 | 400,400.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 298,100.00 | 297,978.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,593,600 | 1,593,600 |
| **2105** | **Нормативт зардал** | 88,139,100 | 45,513,250 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 746,400 | 746,400 |
| 210502 | Хоол, хүнс | 85,057,500 | 42,431,650 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,335,200 | 2,335,200 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,412,400 | 1,412,400 |
| 210604 | Урсгал засвар | 1,412,400 | 1,412,400 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 355,800 | 354,000 |
| 210702 | Дотоод албан томилолт | 355,800 | 354,000 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 720,000 | 720,000 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 720,000 | 720,000 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 4,888,900 | 23,799,649 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 600,000 | 19,510,749 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,288,900 | 4,288,900 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 34,372,500 | 32,033,150 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 00 | 00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 34,372,500 | 32,033,150 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 34,372,500 | 32,033,150 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,213,033,200 | 1,202,928,744 |

| | | | |
|---|---|---|---|
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,159,672,800 | 1,153,474,238 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 00 | |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,159,672,800 | 1,153,474,238 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 52,760,400 | 48,854,506 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 52,760,400 | 48,854,506 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | | |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 600,000 | 600,000 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 600,000 | 600,000 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 76 | 76 |
| 620001 | Удирдах ажилтан | 01 | 01 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 58 | 58 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 17 | 17 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| I | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **34,578,243.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **34,578,243.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **34,578,243.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 433,822.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 8784478.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 8,784,478.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 24,759,943.00 |
| 213403 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг | 600,000.00 |
| II | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 34,578,243.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 34,578,243.00 |
| 131102 | Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл | 8,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 24,759,943.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,818,300.00 |
| IV | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Алтай сумын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн зарцуулалт, и баримт бүрдүүлэлт, шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Хо Өрлөгийн Үрс аудит ХХК-ны аудитор А.Оюундэлгэр 2022 оны 02 дугаар сарын 13-нээс 2021 оны 02 дугаар сарын 24–ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд Шилэн дансны тухай хуультай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Үенч сумын хүүхдийн сургууль нь сумын сургуулийн насны бүх хүүхдийг боловсролын үйлчилгээнд бүрэн хамруулан сургах ажлыг үр дүнтэй зохион байгуулж сургалтын чанарыг сайжруулах, суралцагчийн бие бялдар авьяас чадварыг хөгжүүлэх үйлчилгээг хүргэж хамтарч ажиллах , Монгол улсын засгийн газраас баталж гаргасан тогтоол, шийдвэр, аймаг суманд хэрэгжиж байгаа дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааг сурталчлах, үр дүнг нээлттэй болгон ажиллаж байгаа ерөнхий боловсрол эзэмшүүлэх байгууллага юм.

*Тайлант хугацаанд дараах зорилтууд хэрэгжүүлэн ажилласан байна.*

- *Тус байгууллага нь 2021 онд "Танхимын сургалт удаан хугацаагаар зогссоны улмаас хүүхдийн дунд үүсэж болзошгүй тугшуур, хөгжлийн ялгаатай байдал, сурлагаар хоцрох, сургууль завсардах зэрэг эрсдэлээс сэргийлэх хариу арга хэмжээ авна.*
- *Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн үед хичээл, сургалтын үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэх бэлэн байдлыг хангаж, сургалтыг танхимын болон танхимын бус хосолсон хэлбэрээр хүүхдийн сурах үйл, оролцоог дэмжин тэгш хүртээмжтэй, чанартай зохион байгуулна.*
- *Багш ээлжит хичээлийн бэлтгэлийг чанартай бэлтгэж, үр дүнтэй хэрэгжүүлнэ.*
- *Багш ажлын байрандаа тасралтгүй хөгжих, мэдээлэл технологийн ур чадварыг хөгжүүлэх, заах аргын нэгдэл, сонирхлын бүлгээр хамтран цахим хичээл, хэрэглэгдэхүүн бэлтгэн сайжруулна.*
- *Ахлах ангийн суралцагчдад мэргэжлээ зөв сонгох,ЭЕШ-д амжилттай бэлтгэхэд бүх талын оролцоотой хамтарч ажиллана.*
- *Эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн оролцоо, түншлэлийг өргөжүүлнэ" гэсэн зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна.*

*Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:*

- *Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор "төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай"*
- *Засгийн газрын 2021 оны 8 дугаар сарын 11-ны 237 тоот тогтоолоор "үдийн хоолны норматив шинэчлэх тухай"*

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон бөгөөд 2019 оноос шинэчлэгджээ.

Ковид-19 цар тахалтай холбоотойгоор Санхүүгийн хяналт аудитын дотоод аудитын алба тус байгууллагад дотоод хяналт хэрэгжүүлээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Үенч сумын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьаар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвөөр сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "Бага" гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны нийт орлого 1247,6 сая төгрөгөөс 2 хувиар тооцон 24.9 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 19.9 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Үенч сумын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 90.2 мянган төгрөгөөр буюу 0.4 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна.

Авлагын оны эхний үлдэгдэл 3,3 сая төгрөгийн үлдэгдэл байсан нь тайлант онд 2.8 сая төгрөг төлөгдөж шинээр 13,0 сая төгрөгийн авлага үүссэн байна. 2021 оны 12 дугаар сарын 23-нд аймгийн Засаг даргын А/840 тоот захирамж гарч Санко Маркет Монголия ХХК-аас Ухаалаг самбар авах гэрээ хийгдэж, 13,000.0 мянган төгрөгний байгууллагаас авах авлага нэмэгдсэн байна.

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 44.4 сая төгрөгөөс 39,6 сая төгрөг болж 4,8 сая төгрөгөөр буурсан байна. Төсвийн хөрөнгөөр 62.1 сая төгрөг, хандиваар 1.7 сая

төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 68.6 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 3294.3 сая төгрөг, оны эцэст 3198.7 сая төгрөг болж 95,6 сая төгрөгөөр буурсан байна. Төсвийн зохицуулалтаар 6.0 сая төгрөгийн зохицуулалт хийлгэж зурагт дотор гадна камер утас диска рам, хүлээн авагч дагалдах хэрэгсэл уур сорогч , чанга яригч угаалгын машин, Төсвийн хөрөнгөөр авсан ном 0.3 сая, Хандиваар ирсэн тоног төхөөрөмж 35.5 сая төгрөг төслийн хөрөнгөөр 1.7 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, тайлант хугацааны элэгдлийн зардал 131.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Оны эхэнд 3.3 сая төгрөгийн авлага байсан ба тайлант онд 13.5 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. Тогооч Цэндхүүгээс авах 0.5 сая төгрөгийн авлагын үлдэгдэл. 2021 оны 12 дугаар сарын 23-нд аймгийн Засаг даргын А/840 тоот захирамж гарч Санко Маркет Монголия ХХК-аас Ухаалаг самбар авах гэрээ хийгдэж, 13 сая төгрөгийн байгууллагаас авах авлага нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 3341,9 сая төгрөг байсан оны эцэст 3251.8 сая төгрөг болж тайлант онд 90.0 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт 1.7620,2 сая төгрөгийн бичилт хийсэн. ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 1762,9 мянган төгрөг болсон байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Үенч сумын сургууль нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1149,5 сая төгрөгөөр, нийт зарлагыг 1149,5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчаас тус байгууллагын төсвийг 1149.5 сая төгрөгөөр батлан ирүүлж, тайлант хугацаанд төсвийн тодотгол нэг удаа хийгдэж 1229.7 сая төгрөг болж 80.2 сая төгрөгөөр өссөн байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 1229.7 сая төгрөгийн төсөв баталснаас 1160.3 сая төгрөгийг улсын төсвөөс төсвөөс, төгрөгийг орон нутгийн төсвөөс, 600,0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1160.3 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 52.1 сая төгрөг туслах үйл ажиллагаанаас 0,6 сая орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1202,5 сая төгрөгийг зарцуулж 10.0 сая төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1202.5 сая мянган төгрөг буюу 97,8 хувьтай байгаа нь байр ашиглахтай холбоотой тогтмол зардлыг 4.3 сая мянган төгрөгөөр, хангамж материалын зардлыг 0,04 сая төгрөгөөр, нормативт зардлыг 5.7 сая төгрөгөөр, тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар 2.2 сая төгрөгийн татан төвлөрүүллийн буцаалт, дээд шатны төсвийн захирагчаас 18.2 сая төгрөг, түрээсийн сурах бичгийн үнэ 0.1 сая төгрөг, түрээсийн орлого 1.9 сая төгрөгөөр, нийгмийн даатгалын сангаас 4.2 сая төгрөгийн төсөл хөтөлбөр 8.0 сая төгрөгийн орлого тус тус орж нийт 34.6 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт орсон байна. Нэмэлт санхүүжилтийн данснаас түрээсийн сурах бичгийн үнэ 0.1 сая төгрөг , хөтөлбөр арга хэмжээнд 8.0 сая хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан багш нарын тэтгэмжид 18.2 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогод 0.6 сая , актын төлбөрт 0.6 сая бичиг хэргийн зардалд 0.4 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 3.1сая төгрөг, нийгмийн даатгалын лист 4.1 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АДБОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

АДБОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 79 мэдээллийг хугацаандаа бүрэн мэдээлж 72 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар заалны түрээсийн орлогыг төрийн сангийн харилцах дансаар дамжуулаагүй, эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийн тооллого хийсэн боловч үр дүнг тооцож бүртгэлд тусгаагүй зарим эд хөрөнгийг багцалсан бөөн дүнгээр бүртгэсэн гэсэн 2 зөвлөмж өгөгдсөн бөгөөд 100 хувь хэрэгжүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх, анхаарал хандуулахуйц асуудал байна. Аймгийн Засаг дарга 2021.12.15-нд А/778 тоот захирамжийн 1 дүгээр хавсралтаар боловсролын байгууллагуудад төсвийн зохицуулгыг 649.7 сая төгрөгөөр, 2021 оны 12.23-нд А/842 тоот захирамжийн 2 дугаар хавсралтаар боловсролын байгууллагуудын төсвийн зохицуулалтыг 16.9 сая төгрөгөөр, 2021.12.23-ны А/842 тоот захирамжийн 2 дугаар хавсралтаар Боловсролын байгууллагуудын төсвийн зохицуулалтыг 275.3 сая төгрөгөөр нийт 941.9

сая төгрөгийн зохицуулалт хийжээ. Үүнээс 13 сургууль ухаалаг самбар авна гээд үдийн хоолны зардлаас 195,0 сая төгрөгийг зохицуулалт хийж, Санко маркетинг монголия ХХК гэрээ хийж одоо хүртэл самбар нь ирээгүй дээрх байгууллагууд 195,0 сая төгрөгөөр авлагаа нэмэгдүүлсэн байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 215.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 0.1 сая төгрөгийн 1 залруулга , алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 214.9 сая төгрөгийн 5 зөвлөмж өглөө.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар ХАОАТ 0.1 сая төгрөг илүү шилжүүлсэн авлагаар бүртгээгүй

Шийдвэрлэсэн: Залруулга хийлээ.

***2 Төлбөрийн акт***

Төлбөрийн акт тогтоогоогүй.

### 4.3 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй байна.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### *4.4.1 Төсвийн зарцуулалтай холбоотой асуудал*

*4.1 Илрүүлэлт:.* Төсвийг зүйл хооронд нь гүйлгэн зарцуулж журмын дагуу зохицуулалт хийгдээгүй 5.7 сая төгрөгийн алдаа байна.

*4.1 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн* 16.5.5."батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" заалтыг мөрдөн ажиллах.

#### *4.4.2 Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал*

*4.2 Илрүүлэлт:.* Үндсэн хөрөнгийн тооллогын бүртгэлээр 64 нэр төрлийн тоног төхөөрөмж 6.4 сая, тавилга эд хогшил 89 нэр төрлийн 1.9 сая нийт 8.3 сая төгрөгийн актлах хөрөнгийг актлаагүй, он дамжин оршин байсаар байна.

*4.2 Өгсөн зөвлөмж:* Үндсэн хөрөнгийн бүртгэлд дотоод хяналт хэрэгжүүлэн, дээд шатны байгууллагаар шийдвэрлэн, хөрөнгийн тооллогыг хагас бүтэн жилээр үнэн зөв хийж, бүртгэлд тусгах

#### *4.4.3 И баримттай холбоотой асуудал*

*4.3 Илрүүлэлт:* бараа материалын 55 гүйлгээний 23.6 сая төгрөгийн И баримт аваагүй гүйлгээ хийсэн байна.

*4.3 Өгсөн зөвлөмж:* "Татварын ерөнхий хуулийн 28.5.Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй" заалтыг мөрдөн И баримтаар гүйлгээ хийдэг байх

#### *4.4.4 Шилэн дансны хуулийн хэрэгжилт*

*4.4 Илрүүлэлт:* Шилэн дансны 27 мэдээ 470.9 сая төгрөгийн мэдээлэл хугацаа хоцорсон. 27 нь 1, 4, 6,7,9, сард хоцорсон байна

*4.4 Өгсөн зөвлөмж:* " Шилэн дансны тухай хуулийн 4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" заалтыг мөрдөн ажиллах.

### *4.4.5 Засгийн газрын 43 тоот тогтоолтой холбоотой асуудал*

*Илрүүлэлт1:* Анх 1149.5 сая төгрөгийн төсөв баталж 80.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тайлант хугацаанд 10.0 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна. Батлагдсан төсөвт зардлын 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаагүй 185.5 сая төгрөгийн хэмнэх зардлыг хэмнээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны 43 дугаар тогтоолын холбогдох заалтуудыг баримталж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Үенч сумын сургууль | 6 | 215.0 | 1 | 0.1 | 0 | 0.0 | 0 | 0 | 5 | 214.9 |

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР: А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

ХО ӨРЛӨГИЙН ҮРС АУДИТ ХХК-НЫ

АУДИТОР: А.ОЮУНДЭЛГЭР